

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ	ТОМИЛОЛТ	АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ
БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙН УРТ ХУГАЦААНЫ ТЭЗҮ-Г ХҮЛЭЭН АВЛАА	71.6 САЯ АМ.ДОЛЛАРЫН ТӨСӨЛ ХӨРСӨН ДЭЭР БУУХ НЬ...	
II нүүрт	II-III нүүрт	

Дугаарын 60 мөр

Оюутнуудад нэг сар хотын соёл заая

О.УЯНГА

Манай улсын боловсролын систем их сонин тогтолцоотой. Дунд сургуульд 10 жил үзсэн хичээлийг их, дээд сургуулийн эхний нэг жилд дахиж судалдаг. Ямар ч учиртай тэгдэг юм, бүү мэд. Бүх хүүхдүүдийг 10 жилдээ юу ч сураагүй гэж боддог нэг дарга нь ийм тогтолцоог шийдэж өгсөн юм болов уу. Эсвэл дөрвөн жилийг гүйцээхийн тулд багш нарт заах хичээл олддоггүй ч байж магадгүй юм. Тэгвэл бүтэн жил ерөнхий эрдмийн хичээлүүдийг дахин судалж байхаар өөр юм зааж байвал яасан юм бэ. Жишээлбэл, хотын соёл. Ядаж явган хүн замын хөдөлгөөнд яаж оролцох вэ. Ногоон гэрэл, цагаан шугам. Хогоо хогийн саванд хаях, хаа хамаагүй бие засахгүй байх гээд наад захын соёлыг оюутнуудад заамаар байгаа юм. Өнөө цагт дунд сургуулийн хүүхдүүдэд хотын соёлын талаар түй ч заахгүй байгаа шүү дээ. Яах вэ, Улаанбаатар хотын зарим сургуулиуд сайн дураараа шахам зарим зүйлийг заадаг байх.

Үргэлжлэл нь II нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ЗАСГИЙН ГАЗАР ЗОРИГТОЙ АЛХМААСАА ЯАГААД БУЦАВ

Н.ПУНЦАГБОЛД

Монголын эдийн засаг элгээрээ мөлхөхөөс арай наагуур байгаа талаар амтай болгон л ярьж байна. Сангийн сайд нь ажлаа авсныхаа дараа янз бүрийн тоо хэлж, улс орон дампуурах дээрээ туллаа гэсэн. Эдийн засагчид ч түүний ярьсан тоо баримтыг үнэн гэж батлаад байгаа. Мөн Монголбанкнаас ч гэсэн эдийн засгийн хүндрэл тулж ирсэн энэ үе давах ёстой арга хэмжээгээ авлаа хэмээн мэдэгдэж, бодлогын хүүтээ өсгөсөн. Дээрээс нь Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хасах, танах, хэмнэх тухай маш зоригтой мэдэгдлүүдийг хийж, хамгийн дуулиантай нь төрийн өмчийн компаниудын захирлын санаанд багтамгүй өндөр цалинг бууруулах асуудлыг ярьсан. Дээрээс нь татвар нэмэх бодлого барихаа

мэдэгдсэн. Төрийн албан хаагчид, дарга нарын элдэв хангамжийг ч хасах шийдвэр гаргаж, зоригтойхон ажиллахаа мэдэгдсэн билээ. Гэвч эцэстээ эрх баригчид хийх гэж байсан хамгийн зоригтой алхмаасаа яагаад ч юм буцлаа. Юун хэмнэх, 20, 30 саяын цалин хангамжтай дарга нарын цалинг хасах. Хий боргоод, хазаж чадахгүй тойрч хуцдаг нохой шиг л юм боллоо. Харин татвар нэмэх тал дээр тэд бодлогоо хэрэгжүүлэх бололтой. Өөрсдийнхөө халаасруу биш иргэдийнх рүү гар дүрэх нь зөв гэж үзэж. Тэр дундаа дундаж амьдралтай иргэдийн халаасыг тэмтрэх нь. Тиймээс тэд дарга нарынхаа цалин хангамжийг хасах зоригтой шийдвэрээсээ яагаад буцав гэдгийг хэдэн таамаглалаар шинжих гээд үзье.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр +16

Шөнө +5



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Б.БАТЦЭРЭН:

ӨМНӨХ УИХ БҮРЭН ЭРХИЙНХЭЭ ХУГАЦААНД БАГТААЖ, БАТАЛСАН ХУУЛИЙНХАА ЭЦСИЙН НАЙРУУЛГЫГ ХИЙЖ, ЁСЧЛОХ ЁСТОЙ БАЙСАН

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс

ИЛҮҮ ИХИЙГ БҮТЭЭХ ХҮЧ

INSPIRON 3000 SERIES

Бид таны ажлыг хөнгөвчилнө

Inspiron 3000 загварын авсаархан, хөнгөхөн нөүтбүүкүүд нь таны хэрэгцээнд тохируулсан HD LED дэлгэц, Intel® процессортой учир таны төсөөлснөөс ч илүүг бүтээж чадна.

Онцгой урамшуулал

Dell брэндийн 3000 серийн нөүтбүүк худалдан аваад Targus брэндийн үүргэвчийг бэлгэнд аварай.

Бэлгэнд

- Үүргэвч
- 2 жилийн баталгаа
- McAfee вирусын програм

www.facebook.com/PCmallOfficial

www.instagram.com/PCmall_Official

Биднийг дагаарай

7575-3535

Хаяг: PC Mall төв: Их сургуулийн гудамж 31/1, Ш/Х: 346, Улаанбаатар - 14193, Сүхбаатар дүүрэг - 8

ХААН банк					Худалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах		
АМ.ДОЛЛАР	2200.00	2228.00	ФУНТ	2876.00	2981.00	АМ.ДОЛЛАР	2200.00	2233.00	ФУНТ	2858.00
ЕВРО	2442.00	2514.00	РУБЛЬ	32.10	35.10	ЕВРО	2407.00	2538.00	РУБЛЬ	31.35
ИЕН	21.10	21.76	ЮАНЬ	328.80	333.30	ИЕН	20.72	21.98	ЮАНЬ	325.00
										334.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Утас: 976-70113551

Факс: 976-70113551

УЛС ТӨР

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

БАГАНУУРЫН НҮҮРСНИЙ УУРХАЙН УРТ ХУГАЦААНЫ ТЭЗҮ-Г ХҮЛЭЭН АВЛАА

Х.НОРЖИН

Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэглээ өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулж бүх боломжит хувилбарыг тусгасан Багануурын уурхайн урт хугацааны буюу хаалт хүртэлх Техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг олон улсын стандартын дагуу боловсруулж хүлээлгэн өглөө. Уг үйл ажиллагаанд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Б.Бямбасайхан, “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Отгонбаяр болон Эрчим хүчний яам, Дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл, Ранги Пинкок Минарко, Балчулуу компанийн төлөөллүүд оролцлоо. 2014 онд Багануурын уурхай нөөцөө нэмэгдүүлэх зорилгоор ордын хэмжээнд геологи хайгуулын ажлыг Норвест, Эрдгео компаниудаар хийлгүүлж, нүүрсний нөөцийг 274 сая тонноор нэмэгдүүлж 812 сая тонн болгосон юм. Уг нөөц дээр тулгуурлан Австралийн Ранги Пинкок Минарко болон Балчулуу компаниуд өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний нүүрсний хэрэгцээг хэрхэн хангах, техник технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хэрхэн хийх эсрэг техник, эдийн засгийн тооцооллуудыг боловсруулж гүйцэтгэв. Тодруулбал, Багануурын уурхайн хүчин чадлыг 2018 онд 6.5 сая тонн, 2019 онд 8.0 сая тонн, 2020 онд 10.0 сая тонн хүртэл нэмэгдүүлж, ил уурхайн эцсийн гүнгийг 300 метр хүртэл ашиглалт явуулахаар тооцоолов. ТЭЗҮ-г хүлээлгэн өгөх арга хэмжээний үеэр “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “Багануурын уурхай Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 70, төвийн бүсийн



60 хувийг дангаараа хангадаг. Багануурын уурхайн нүүрсний нөөц өнөөдрийн байдлаар 812.0 сая тонн байна. Энэ нөөцдөө тулгуурлан жилд 10.0 сая тонноор олборлолт хийнэ гэж тооцвол Монголын эрчим хүчний нүүрсний эрэлтийг 60 гаруй жил тасралтгүй хангаж чадна. Өнгөрсөн хугацаанд Багануурын уурхай дэлхийн уул уурхайн салбарт арвин туршлагатай Норвест, Эрдгео компаниудаар геологи хайгуулын ажлыг хийлгүүлж, олон улсын санхүүгийн тайлагналын стандартын дагуу Эрнст Янг компаниар аудит хийлгэсэн. Түүнчлэн олон улсын стандартын дагуу үнэлгээ хийлгэж, ТЭЗҮ-ээ шинэчлэлээ. Эдгээр бүх ажлууд нь олон улсын хөрөнгийн бирж дээр хувыцаагаа гаргах, хөрөнгө оруулалт татах, техник технологийн шинэчлэл хийх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Өнөөдөр хүлээн авч байгаа урт хугацааны

ТЭЗҮ нь олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилт авахад чухал шаардлагатай бичиг баримт болно” гэдгийг онцлов. “Урт хугацааны ТЭЗҮ-д үйлдвэрлэлийн нөөцөөр тодорхойлсон 577.0 сая тонн нүүрсийг эдийн засгийн хувьд үр ашигтай олборлох, борлуулах боломжтойг тодорхойлсон. Хамгийн үр ашигтай хэсэг нь ордын хойт хэсэгт байрлалтай, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр батлуулсан ашиглалтын нөөцийн хэмжээнд тохируулан нүүрсний борлуулалтын үндсэн үнэ 40 хувь өсөх нөхцлөөр тооцсон оновчлолын үр дүнд үндэслэн уурхайн загварчлалыг хийсэн” гэж “Багануур” ХК-ийн Гүйцэтгэх захирал М.Отгонбаяр арга хэмжээний үеэр хэллээ. **Багануурын Нүүрсний уурхайн урт хугацааны ТЭЗҮ-ийн тухай Гүйцэтгэгч талууд:** -Ранги Пинкок Минарко (Австрали) Runge Pincok Mi-

-Балчулуу ХХК Захиалагч талууд:

-МУ-ын Засгийн Газар

-МУ-ын Эрчим хүчний яам Дэлхийн банкны Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)

Багануур ХК Урт хугацааны ТЭЗҮ нь Дэлхийн банкны санхүүжилтээр “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд программ хангамж, геологи уул уурхайн зураг төсөл, судалгааны Ранги Пинкок Минарко болон Балчулуу ХХК-аар боловсруулагдан гүйцэтгэгдэв. Багануурын уурхайн анхны ТЭЗҮ-ийг ОХУ-ын Гипрошахт институт боловсруулан жилд 1.0-4.0 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтайгаар ашиглалтад оруулж байжээ. Улс орны хөгжлийг дагаад эрчим хүч, дулааны хэрэгцээ огцом өсч цаашид эрчим хүчний нүүрсний хэрэглээ жил бүр нэмэгдэх тооцоо байна. Тодруулбал, ДЦС 5, ДЦС 4 өргөтгөл, ДЦС 3 250 МВ-ийн өргөтгөл мөн Багануур дүүрэгт 700МВ-ийн цахилгаан станц баригдана. Мөн уурхайг түшиглэн хагас кокс болон хийжүүлэх үйлдвэр, нүүрс шингэрүүлэх үйлдвэрүүд баригдахаар төлөвлөгдсөн бөгөөд эдгээр үйлдвэрүүд жилд 1-2.0 сая тонн нүүрс авна. Иймд 2020 онд Багануурын уурхайн хүчин чадлыг 10.0 сая тонн-д хүргэх зайлшгүй шаардлагатай байгаа юм.

Дугаарын **60** мөр

Оюутнуудад нэг сар хотын соёл заая

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Хөдөөд бол бүр ч хэцүү. Үүгээрээ хот, хөдөө гэж ялгах гэсэн юм биш шүү. Яг бодит байдал дээр бол хотод өссөн, хөдөө амьдарч байсан хүүхдүүд ялгаатай л байгаа. Ядаж л хаа хамаагүй шээх тал дээр өөр өөр биз дээ. Үүнтэй эвлэрэх цаг болсон. Саяхандаа цахим ертөнцөөр хэдэн оюутны зураг яваад байсан. Сургуулийнхаа хана руу харчихсан хээв нэг шээгээд зогсч байгаа юм. Тэднийг хөдөөнөөс ирсэн, эсвэл хотынх уу гэдгийг хэлж мэдэхгүй. Гэхдээ нэг л үнэн юм байна. Тэдэнд ёс суртахуун, соёл гэж алга. Сургууль руугаа гүйж ороод л бие засчих боломжтой байхад хаалга руу нь харчихсан, зүлэг ногоон дээр хээв нэг “морь харж” байх жишээтэй. Ийм байж болохгүй ээ. Үнэхээр давсаг нь хагарчих гээд, ойр хавьд ороод бие засчих газар байхгүй үед хүн харахааргүй газар, байшин сав, гараашны араар ороод “аваад хаячих” тохиолдол байхыг үгүйсгэх аргагүй. Ядаж байхад манай албан байгууллагууд, үйлчилгээний газрууд 00-оо тэр болгон ашиглуулах биш. Эсвэл үнэтэй байдаг. Харин эрдмийн уурхай болсон сурах сургуулийнхаа хажууд, хотын төвд, олон хүний хөл хөдөлгөөний үеэр хээв нэг шээгээд зогсч байна гэдэг бол бүдүүлгээс ч цаагуур асуудал. Тиймээс хотын соёл гэдгийг наад захын зүйлээс нь эхлээд заамаар байна. За тэр ерөнхий эрдмийн хичээллүүдээ бүгдийг нь заахаа больдоггүй юм гэхэд зарим нэгийг нь хасаад, оронд нь хотын соёлыг оюутнуудын толгой руу хийж өгөөч. Ядахын мууд нэг сар зааж өгөөд, ухуулаад, ойлгуулбал хүүхдүүд арай л өөр болно доо. Ядаж л хогоо хогийн саванд хийгээд, гарцаар, ногоон гэрлээр гараад, хаа хамаагүй шээхээ больчихвол аятай юу. Өнөөдөр залуучууд, хүүхдүүд том чихэвч зүүгээд, дуу сонсч байхдаа зам хөндлөн гардаг. Бүр гарцгүй газраар мал шиг л дайрдаг. Эргэн тойрноо харахгүй, машин ирж байгааг ч анзаардаггүй. Дуут дохио өгөөд ч сонсохгүй. Үүнээс нь болж авто осол гарч, залуус бэртэж гэмтэж, цаашлаад амь насаа хүртэл алдаж байгаа. Нөгөө талд жолооч нар хэрэгтэн болдог. Уг нь явган зорчигчийн буруу байдаг ч хүний эрүүл мэнд, амь насыг хохироосон гээд л “авын хаалга” татах болдог. Энэ мэтээр өнөөдөр залуусын толгой тархинд суулгаж, ойлгуулж өгөх олон асуудал байна. Тиймээс хичээлийн программд суулгаад өгчих хэрэгтэй шүү дээ. Нэг талаас хотын соёл гэж өнгөд мэт харагдаж байгаа ч цаагуураа хүн болоход нь хэрэгтэй.

ТОМИЛОЛТ

71.6 САЯ

Н.БАТЗАЯА

Юуны өмнө ложистикийн үйлчилгээний талаар хэдэн тайлбар хэлэх нь зүйн хэрэг болов уу. Ложистик гэж хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, зорилгод нийцүүлэн аливаа түүхийг эд, бараа, үйлчилгээ, мэдээлэл, санхүүгийн хөрөнгийг эхлэл цэгээс зорилтот цэг хүртэл хамгийн үр ашигтайгаар зөөвөрлөх, баглан боох, бэлэн бүтээгдэхүүн хадгалах, хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хэлж байгаа юм. Товчхон хэлэхэд зөв зүйлийг, зөв газарт нь, зөв цагт, зөв нөхцөл, зөв зардлаар хүргэж өгөх үйлчилгээ. Зах зээлд ложистикийн салбар маш өргөн цар хүрээг хамарсан, эдийн засгийн бүхий л оролцогчдод хүрч үйлчилдэг амин чухал салбар. Тиймдээ ч манай улс эдийн засгийн зардлыг хэмнэж, үр ашгийг өсгөөд зогсохгүй, хэрэглэгчдэд хүрэх үйлчилгээг нэг дор нэгтгэсэн энэ үйлчилгээг нэвтрүүлэхийг зорьсоор байгаа билээ. Зам, тээврийн хөгжлийн яам Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240” төслийг Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хэрэгжүүлж хэлтээд зургаан жил болжээ. Удаан хөдлөх хэрэгжиж буй уг төсөл манай улсын хэмжээнд үр ашгтай, өрсөлдөхүйц, найдвартай холимог тээврийн системийг хөгжүүлэх чухал ач холбогдолтой. Анх 2011 оны наймдугаар сараас хэрэгжсэн энэхүү төслийн хүрээнд эдүгээг хүртэл нийт 11.729.247.546.000 төгрөгийн ажлыг гүйцэтгэжээ. Тухайлбал, 3.6 км цэвэр усны шугамын ажил, 2.9 км эрчим хүчний шугам болон дэд өргөөний байгууламж, 5.3 км хамгаалалтын хашаа, төмөр замтай хоёр төвшинд огтлолцох гүүрэн байгууламж, 1.6 км авто замын барилга угсралт, 4.15

км гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах, гадна цахилгаан хангамжийн 110kV ЦДАШ, дэд станцын өргөтгөл, дэд станцын барилга угсралтын ажлыг хийж дуусгасан байна. Тэгвэл энэ сарын 2-нд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд Азийн хөгжлийн банкны зээл, буцалтгүй тусламжаар баригдах ложистикийн төвийн барилгын шав тавих ёслолын үйл ажиллагаа боллоо.

Энэхүү үйл ажиллагаанд УИХ-ын гишүүн Б.Дэлгэрсайхан, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжүүлэлтийг зохицуулах газрын дарга Б.Артур, УБТЗ-ын дарга Л.Пүрэвбаатар, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин, Замын-Үүд өртөөний дарга О.Мэндсайхан, БНХУ-аас Замын-Үүд суманд суугаа ерөнхий консул Цай Вэй Рү, Хятадын төмөр зам 21 дүгээр товчоо группийн захирал Гүэ Ян Хун, Хятадын төмөр зам 21 дүгээр товчоо группийн ТУЗ-ийн орлогч дарга Гао Финг зэрэг албаныхан оролцов. Шав тавих ёслолыг нээж, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжүүлэлтийг зохицуулах газрын дарга Б.Артур “Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах ложистикийн төвийн барилгын ажлыг эхэлснийг хэлэхэд таатай байна. Монгол Улсын Засгийн газар уг ажлыг дэмжин Азийн хөгжлийн банктай гэрээ байгуулсан. Энэ хүрээнд Азийн хөгжлийн банкаас төслийн нийт санхүүжилтийн 60 гаруй хувь буюу 45 сая ам.долларын зээл, буцалтгүй тусламжийг үзүүлэхээр болсон. Ложистикийн төвийн барилгын ажил хоёр жилийн хугацаанд явагдана. Энэ хүрээнд Замын-Үүд боомтоор дамжин өнгөрөх экспортын ачааны хяналт, шалгалтын нэг цэгт төвлөрүүлэн ложистикийн үйлчилгээтэй хослуулан өргөн хэмжээний цогц барилга

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Хүндэрсэн Засгийн газрыг аврах гээд байна уу, сүйрүүлэх гээд байна уу

Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад 11 хуулийн төслийг хэлэлцлээ. Хэлэлцүүлгийн шатанд УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат “Гудамжинд хүмүүс асуугаад байна. Хүндэрсэн Засгийн газрыг аврах гээд байгаа юм уу. Сүйрүүлэх гээд байгаа юм уу. Энэ улстөржсөн шийдвэр чинь алдаа болчихоод байна. Сонгуульд гарахдаа амлалт авсан юм байгаа биз дээ. Үүнийг чинь аудит хянаад хэрэгжих боломжгүй гэж үзсэн юм байгаа биз дээ. Ард иргэд бухимдаж байна. Урагшаа харж ажилъя. Сүүлийн 20 хоногийн турш урагшаа харж ажиллаад байна. Улс чинь нэг төсөвтэй байгаа. Гэтэл та нар гурван төсөв зохиочихлоо. Та нар засаг барьсан эрх баригчид шүү дээ. Ингэж гоншигноод байвал орон нутгийн сонгуулиар ялагдана. Ц.Нямдорж гишүүн үнэн хэлсэн” хэмээн бүхмидлаа илэрхийлсэн бол УИХ-ын гишүүн Д.Сарангэрэл “Би Засгийн газар, Сангийн сайд руу улаан лооль руу шидмээргүй байна. Эдийн засгийн хүнд нөхцөл өнөөдөр Сангийн сайд, Ерөнхий сайдыг ийм байдалд оруулчихлаа. Би нэг л зүйл асуух гэсэн юм. Улсад 36 жилээр нь тасралтгүй ажилладаг хэр олон хүн байдаг юм бэ. Энэ хүмүүст өгдөг тэтгэмжийг 12 болгоё

...“Хямралын цаг үе тодорхой хугацаатай арга хэмжээ. Хямрал гайгүй болохоор бид төсвийн бодлогоо сүлруулна. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх гэж бид энэ арга хэмжээг авч байна. Аргаа барсандаа өнөөдөр халамжуудыг танаж байна...

гэх санал орж ирээд байна. 36 жил тасралтгүй ажилласан хүнийг эдийн засгийн боломж сайжиртал тухайн хүнийг ажиллах нөхцлөөр хангах боломжийг судалсан уу” гэж асуухад тэрбээр “Хямралын цаг үе тодорхой хугацаатай арга хэмжээ. Хямрал гайгүй болохоор бид төсвийн бодлогоо сүлруулна. Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх гэж бид энэ арга хэмжээг авч байна. Аргаа барсандаа өнөөдөр халамжуудыг танаж байна. Төрийн сангийн нэгдсэн дансанд 155 тэрбум төгрөг байна. Одоогоор бид 36 жил ажилласан хүмүүсийн хамтаар таны саналыг судлаагүй байгаа” гэв. УИХ-ын чуулганы хуралдаан үргэлжилж, татвар нэмэх асуудал дээр гишүүд нэлээд анхаарал хандуулсан гэхэд болно. Энэ үеэр УИХ-ын гишүүн С.Жавхлан “Манай улс мандан бадарч явах үедээ баялаг ихтэй байсан. Үүнийг хэсэг нөхөд хувааж идээд өнөөдөр чинээлэг хүмүүс болжээ. Уг нь хэлний зүйгээр нь авч үзвэл чинээлэг хүмүүс гэдэг нь чин элэгтэй хүнийг хэлдэг. Чин элэгтэй хүн гэдэг бол түмэн олноосоо хэзээ ч юмаа харамладаггүй. Гэтэл одоо том том эмнэлэг шиг байшинтай хүмүүс зөндөө байна. Бөмбөгөр цагаан гэрээ бариад 5 үнээ, 20-30 ямаагаа саагаад амьдрах цаг ирсэн. Та нар өнөөдөр инээж болно. Ойлогх цаг ирнэ. Та нар байшингаа хүүхдүүдэд зориулсан эмнэлэг болгож өгөөч. Тавтар нэмэх асуудал чинь иргэдэд ерөөсөө таалагдахгүй ээ. Хуучин үзэл баримтлалаараа явах юм

ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



...Ä°îðëé
ñàéä
èàáëíàòàà
ç°âðã°æ
ÿðëòûíðàà
îðííä ÿìàð
àëääà
ääðãñííàà
îëæ ðàð...

УИХ-ын гишүүн
Цэндийн НЯМДОРЖ

АМ.ДОЛЛАРЫН ТӨСӨЛ
ХӨРСӨН ДЭЭР БУУХ НЬ...



Гэрэл зургийг Г.АГЪУУЖИН

баригдах юм. Энэхүү байгууламж баригдсанаар манай улсын импорт, экспорт, дамжин өнгөрөх тээврийн хэмжээ нэмэгдэж эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхээс гадна бүс нутаг дахь тээврийн коридоруудтай өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ. Төслийн хэрэгжилт захиалагч болон санхүүжигч талууд, хэрэгжүүлэх нэгж, зөвлөх баг, барилгын гүйцэтгэгч нарын хамтын чармайлтаас ихээхэн хамаарна гэдгийг онцлон хэлмээр байна. Та бүхэнд ажлын амжилт хүсье” гэв. Төслийн хүрээнд Замын-Үүд боомтын хяналт шалгалтын цэг, ачаа дамжин өнгөрүүлэх газрын ачааллыг багасгах, зохицуулах зорилгоор ачааны холимог тээврийн терминалын аж ахуй, ложистикийн үйлчилгээг бий болгох юм байна. Мөн авто замаас авто зам руу, авто замаас төмөр зам руу байсан төмөр замаас авто зам руу ачих төмөр замын шилжүүлэн ачилтад зориулсан тоног төхөөрөмж, менежментийн системийг нэвтрүүлэх зэрэг терминал ложистикийн байгууламжийг байгуулах ажлууд цогцоороо хийгдэх юм. Уг төсөл нийт 128 га талбайг хамрах бөгөөд чингэлэгийн, хүнд даацын, агуулахын гэсэн гурван бүстэй байхаар төлөвлөгджээ. Түүнчлэн 50

болон 70 тн даацтай гүүрэн кран, механизмын засварын төв, өргөн болон нарийн царигийн ачилт буулгалтын 11.5 км орчим төмөр зам, ложистикийн төв руу орох гарах төмөр замтай хоёр төвшинд огтлолцох хүнд даацын тээврийн хэрэгсэл явах боломжтой гүүрэн байгууламж, 1.6 км авто зам тус тус барихаар төлөвлөгджээ. Энэхүү ложистикийн төвийн барилгын ажлыг “Хятадын төмөр зам 21 дүгээр товчоо” групп гүйцэтгэх гэнэ. Тус компани нь Зам, тээврийн хөгжлийн яамнаас зарласан олон улсын нээлттэй тендерт шалгаран ийнхүү барилгын ажлыг гүйцэтгэхээр болжээ. Барилгын ажлын гүйцэтгэлийн тухай “Хятадын төмөр зам 21 дүгээр товчоо” группийн ТУЗ-ийн орлогч дарга Гао Финг “Манай төмөр зам 21дүгээр групп Монгол Улсын эдийн засгийн томоохон бүтээн байгуулалтын ажилд оролцож байгаадаа баяртай байна. Бид барилгын ажлыг мэргэжлийн өндөр төвшинд, чанартай гүйцэтгэнэгдгээтабүхэнддамлаж байна. Мөн Монгол Улсын хууль тогтоомж, зан заншлыг даган мөрдөж, тогтсон хугацаандаа ажлаа гүйцэтгэж, хүлээлгэн өгнө. Манай компани орон нутгийн хөгжилд өчүүхэн ч гэсэн хувь нэмрээ оруулах болно. Бид ажлаа

чанартай, хурдан хугацаанд гүйцэтгэн хоёр орны хоорондын харилцааг улам бэхжүүлэнэ гэдэгтээ итгэлтэй байна” гэв. Шав тавих ёслолын үеэр ложистикийн төв байгуулагдсанаар улс оронд өгөөжөө өгсөн олон ажил хийгдэнэ гэдгийг албаныхан онцолж байлаа. Тодруулбал, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, барилга, уул уурхайн салбарын том оврын тоног төхөөрөмж болон манай улсын нутгаар дамжин өнгөрөх транзит ачааг шилжүүлэн ачих техникийн боломж нээгдэх гэнэ. Энэ нь Монгол Улс төдийгүй бүс нутаг дахь тээврийн коридоруудтай манай улсын орц, гарц өрсөлдөх таатай боломжийг бүрдүүлэх юм байна. Тус төв нь 24 цагийн үйл ажиллагаатай байх бөгөөд 2-3 ээлжээр ажиллах бүрэн боломжтой аж. Мөн хонотг 600 орчим вагон буюу 12 галт тэрэг БНХАУ-ын талаас хүлээн авч ачиж буулгах, шилжүүлэн ачилт хийх хүчин чадалтай. Эдийн засгийн коридорт өрсөлдөх боломжийг нээж буй уг төв нийт 200 орчим хүний ажлын байр бий болгож байгаа ажээ. Энэхүү төсөлд нийт 76.1 сая ам.долларын санхүүжилт шийдэгдсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газраас 26.6 сая ам.доллар, Азийн хөгжлийн банкаас 40 сая ам.долларын зээл, таван сая ам.долларын буцалтгүй тусламжийг олгожээ. Харин төслийн хэрэгжүүлэгчээр Зам, тээврийн хөгжлийн яам ажиллаж байгаааж. Энэхүү төслийн хүрээнд хийгдэж буй ложистикийн төвийн барилгын ажил 2018 онд дуусах юм. Ложистикийн төв бүрэн ашиглалтад орж, ажиллаж эхэлснээр манай улсын эдийн засгийн гарц нээгдэнэ гэдгийг салбарын мэргэжилтнүүд онцлов. Ямартай ч аль 2011 оноос эхлэлтэй төслийн ажил дундарч, ложистикийн төвийн барилга баригдан 76.1 сая ам.долларын төсөл хөрсөн дээр буух нь...


Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Засгийн газар цалин хасахаас юунд айв

Яг ч айх гэж тодорхойлоход бас хэцүү юм. Тэд зүгээр л 30, 40 саяын цалин урамшуулалттай төрийн өмчит компанийнхаа дарга нарын атганд орчихсон юм биш үү. Ер нь энэ засгийн эрхийг хэн бариад байгаа юм бэ, олон саяын цалинтай дарга нар юм биш биз. Уг нь тэр олон саяын цалинг нь тодорхой хувиар хасч, бага ч болов мөнгө хэмнэх нь хамгийн зөв шийдэл байсан юм. Харам-

...Манайд улс эх орноо боддог сэтгэлтэй улстөрч гэж түй ч алга. Тэр нам, энэ хүчин гээд байх юм алга. Аль нь ч ялгаагүй. Тэр дундаа МАН-ынхан ард түмэнд л таалагдаж байвал бусад нь яах вэ гэсэн бодлогоосоо огт ухарч чадсангүй. Сонгуулиас хойш хийсэн, хэлсэн, хийх гэж байсан бүхэн нь АН-ын өнгөрсөн дөрвөн жилийг хараар будах л тактик байсан юм биш үү...

ЗАСГИЙН ГАЗАР ЗОРИГТОЙ АЛХМААСАА
ЯАГААД БУЦАВ



салтай нь МАН-ынхны хүч хүрсэнгүй. МАН гэхээсээ илүүтэй Ж.Эрдэнэбатын хүч хүрээгүй ч байж болох. УИХ-ын дарга гүйцэтгэх засаглалын тэргүүнээ “базаж” байгаа нь мэдээж. Тэгээд ч сүүлийн үед Засгийн газар болон 65-ын бүлэг хагаралдаж эхэллээ гэсэн мэдээлэл гарах болсон. Ж.Эрдэнэбатыг огцруулах гарын үсэг цуглуулж байгаа ч гэх шиг. Энэ бүхнээс харвал төрийн өмчит компаниудын өндөр цалинтай дарга нар УИХ-ын дарга болоод гишүүдээр дамжуулж Засгийн газарт “салаавч” өгсөн ч байж болох юм. Хэрвээ төрийн өмчит компанийн захирлуудын цалинг хөндвөл дэд сайдын албан тушаалыг ч бас “арчих” шаардлага тулгарсан. Хүн бүр л энэ бүхнийг зэрэгцүүлэх ёстой гэсэн байр сууринаас хандаж байсан нь зориглож хийсэн алхмаасаа ухрахад хүргэсэн ч байж болох. Ямар ч байсан МАН-ынхан өөрсдийнхөө, дарга нарынхаа тансаглалыг хэвээр нь үлдээхээр шийдлээ. Харин татвар нэмэх бодлогоо бүлгээрээ дэмжсэн. Тэгэхээр цаашлаад УИХ дээр цэрэгжилтийн байдлаар гараа өргөөд л дэмжчих байлгүй дээ. Тэдэнд өндөр цалинг танаж, дэд сайдын суудлаа буцаах зориг дутлаа. Зориг дутсан гэхээсээ илүү албан тушаалын наймаа нь саад болсон ч байж болох юм. Ямар ч байсан тэд хүүхдийн мөнгийг бол хасчихаад, дарга нарыг өндөр цалинтай нь л үлдээлээ.

Эрх баригчид мөнгө олчихов уу

Бүгдийг хасна, танана, хэмнэнэ гэж байсан хүмүүс гэнэт л зөөлрөөд эхэллээ. Хасахгүй, танахгүй байя гэж шийдсэн. Хэдийгээр татвар нэмэхийг МАН-ын бүлэг дэмжсэн ч УИХ дээр унагаж ч магадгүй. Ийн гэнэт зөөлөрч эхэлж байгаа нь тэд мөнгөтэй болсон юм биш байсан гэх хардлагыг дагуулж байна. Ерөөсөө эрх баригчид хаанаас мөнгө олж болох бүхий л арга замыг хайж байгаа нь тодорхой. Гэхдээ сүүлийн үед МАН-ынхан урд хөршөөс

багагүй мөнгө авахаар болсон байж магадгүй гэх мэдээлэл яваад байгаа. Үүнийг бас огт үгүйсгэх аргагүй. Тэгээд ч манайд удахгүй “Bank of China” салбараа нээх тухай яриа газар авсан. Ер нь нээчихсэн юм биш үү. Есдүгээр сарын 1-нд оюутнууд “Bank of China”-гийн тэтгэлгийн батламж гардаж аваад байсан. Эсвэл Хятадын Засгийн газраас багагүй зээл авч, эдийн засгаа мөнгөөр тэтгэхээр болсон ч байж болох. Нэгэнт нөхдүүд мөнгөтэй болчихвол дарга нарын цалинг хасаад, төсөв хэмнэнэ гэж муухай царйлаад байх шаардлагагүй. Татвар нэмэхээ ч больж мэдэх юм. Энд нэг зүйл сануулахад, энэ ердөө л хардлага шүү.

Орон нутгийн сонгуулийн өмнө муухай харагдаж болохгүй байв уу

УИХ болоод аймаг, нийслэлийн сонгууль болж, МАН үнэмлэхүй ялалт байгуулсан. Ард түмэн тэднийг аврагчаар томилсон ч одоохондоо бидэн рүү “аврах хантааз” шидээгүй л байна. Харин ч эсрэгээрээ чадалтай нь сэлж гараад, чадахгүй нь жив гэсэн бодлого барьж байгаа юм. Бүхий л зүйлийг хаслаа, таналаа гээд л давхив. Оюутны 70, хүүхдийн 20, төрийн албан хаагчдын урамшуулал энэ тэр гээд. Гэтэл гэнэтхэн зангаа хувиргаж, арай өөр шийдтээр өгөхөөр амласан. Хүүхдийн мөнгийг гэхэд эхний ээлжинд 60 хувьд нь шууд өгөөд, үлдсэн 40 хувийнхыг нь гурван жилийн дараа хүүтэй өгөхөөр болов. Оюутны тэтгэлгийг ч гэсэн жилдээ нэг удаа, тэгэхдээ өмнөхөөсөө нэмж олгох талаар ярьж эхэллээ. Юун хасаж, танах. Харин ч бүр нэмнэ гэж байна. Үүнийг орон нутгийн сонгуулийн өмнө ард түмэнд таалагдах гэж хийж байгаа алхам гэж үзэх талтай. Өнөөдөр МАН-ыг сонгосон, тэдэнд итгэсэн олон хүн амаа барьж байна. Сайдын томилгооноос эхлээд л тэд ямархуу хүмүүсийг сонгож, төрд илгээснээ мэдэж буй биз. МАН-ынхан ч гэсэн

иргэдийн санаа бодол яаж эргэж байгааг хоёр, гуравхан сарын дотор мэдэрсэн буй за. Тиймээс орон нутгийн сонгуулийн өмнө иргэдэд таалагдах гэж халамж, хэт өндөр цалинг хасах зоригтой шийдлээсээ ухрав.

Ердөө л АН-ыг харлуулах гэсэн тоглоом байв уу

Манайд улс эх орноо боддог сэтгэлтэй улстөрч гэж түй ч алга. Тэр нам, энэ хүчин гээд байх юм алга. Аль нь ч ялгаагүй. Тэр дундаа МАН-ынхан ард түмэнд л таалагдаж байвал бусад нь яах вэ гэсэн бодлогоосоо огт ухарч чадсангүй. Сонгуулиас хойш хийсэн, хэлсэн, хийх гэж байсан бүхэн нь АН-ын өнгөрсөн дөрвөн жилийг хараар будах л тактик байсан юм биш үү. Сангийн сайд нь гарч ирээд хийсэн мэдэгдэл нь АН-ыг харлуулах. Тэд л ингээд өрөнд оруулчихлаа гэсэн ойлголтыг ард түмэнд өгөх. Дараа нь АН-ын хийсэн муу бүхнээс үүдээд эдийн засаг муудсан учраас бид бүх халамжаа таналаа. Дарга нарын цалинг хаслаа. Төрийн албан хаагчдын урамшууллыг байхгүй болголоо. Энэ бол бидний хийж байгаа юм биш. АН ийм зүйл хийхээс аргагүй байдалд хүргэлээ гэсэн ойлголт өгсөн. Түүнийхээ дараа хасахаа болилоо. Танах нь зөв байсан ч манай нам иргэдээ тэгж элгээр нь хэвтүүлэхгүй. Сөрөг хүчин хэдий эдийн засгийг мөлхүүлсэн ч бид яаж ийж байгааг өндийнө. Уг нь тэр бүхнийг хасах байсан юм. Гэхдээ бид яаж ийж байгаад өгнө. Энэ бол бидний л ач гэсэн ойлголтыг ард иргэдэд өгөхийг оролдож байх шиг байна. Дараагийн сонгууль болтол энэ маягаар тоглох байлгүй дээ. Бас улс орныг ийм байдалд оруулсан хүнд хариуцлага тооцох тухай ярих болов. Тэгвэл 2008 оноос эхэлж халамж тараасан хариуцлагагүй үйлдлээсээ эхлээд хариуцлага тооцохоос өөр аргагүй болох байх даа. Сүүлийн 26 жилд аль нам засгийн эрхийг олон жил барьсан бэ гэдэг асуултыг тавивал хариулт тодорхой шүү дээ.

УЛС ТӨР

АЛБАНЫ ХҮНИЙ ҮГ

Ж.ОТГОНМЯГМАР

Шинэчлэн найруулсан Эрүү болон Зөрчлийн тухай хуулиуд хэрэгжиж эхлэх хугацааг УИХ-ын ээлжит бус чуулганаар 2017 оны долдугаар сарын 01 хүртэл хойшлуулсан билээ. Тиймээс энэхүү хуулийн талаар Монгол Улсын Дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэнтэй ярилцлаа.

-Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль нийгэмд нэлээд хүлээлт үүсгэчихсэн байсан бололтой. Хэрэгжээд эхэлсэн өдрөөсөө иргэдэд шууд мэдрэгдэх заалт олон байсан уу?

-Өмнөх парламентын баталсан Эрүү болон Зөрчлийн тухай хуулиудыг 2016 оны есдүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр заасан байсан. Эдгээр хуулийг багтах хэрэгцээ шаардлага, үзэл баримтлал, ач холбогдлын талаар олон нийтэд хангалттай мэдээлэл,

төгөлдөр хуулиуд юм. Энэ хоёр хуулийг дагаж мөрдөх хугацааг хойшлуулахад олон хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. Өмнөх парламент Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай зэрэг процессын хуулиудын эцсийн найруулгыг хэлэлцэж, албан ёсоор ёсчлоогүй, “Төрийн мэдээллийн эмхэтгэл” сэтгүүлд нийтлээгүй тул эдгээр хуулийг хүчин төгөлдөр гэж үзэх боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно”, Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсэгт “Улсын Их Хурлын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Б.БАТЦЭРЭН: ӨМНӨХ УИХ БҮРЭН ЭРХИЙНХЭЭ ХУГАЦААНД БАГТААЖ, БАТАЛСАН ХУУЛИЙНХАА ЭЦСИЙН НАЙРУУЛГЫГ ХИЙЖ, ЁСЧЛОХ ЁСТОЙ БАЙСАН

суртачилгаа хүрсэн гэж бодож байна. Энэ хэрээр нийгэмд тодорхой хүлээлт бий болсон гэдэгтэй санал нэг байна. Шинэ Эрүүгийн хууль энэ оны есдүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бол түүний үр дагаврыг хамгийн түрүүнд шүүхээр ял шийтгүүлсэн, одоо ял эдэлж байгаа болон гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа хүмүүс хүртэх байсан. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулиар ял шийтгүүлсэн хүнийг үйлдсэн гэмт хэргийнх нь ангиллаас хамаарч хуульд заасан тодорхой хугацаанд ялтайд тооцдог бөгөөд энэхүү статус нь нийгмийн харилцаанд тэгш бус байдлыг бий болгож, тэдний эрх зүйн байдлыг дордуулах нөхцөл болдог. Харин шинэ Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээр “ялтай байдал” гэх хууль зүйн ойлголт байхгүй болж, шүүхээр ял шийтгүүлсэн иргэдийн зарим эрхэд хуулиар тогтоосон хязгаарлалт арилах болно. Одоо ял эдэлж буй хүмүүсийн хувьд шинэ хуулиар тухайн гэмт хэрэгтэнд оногдуулах ялын хэмжээ хөнгөрсөн тохиолдолд ялыг нь шинэ хуульд нийцүүлж өөрчлөх ажиллагаа хийгдэх байсан. Тухайлбал, Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу хорих ял эдэлж буй хүмүүсийн хувьд есдүгээр сард багтааж, харин хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүмүүсийн хувьд арванхоёрдугаар сарын 01-ний дотор багтааж, ялын тэгшитгэлийг хийснээр энэ хүмүүсийн эрх зүйн байдал тодорхой хэмжээнд дээрдэх байсан. Харин одоо гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй хүмүүсийн хувьд шинэ хуулийн дагуу ялтай байхдаа давтан гэмт хэрэг үйлдсэн, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн гэх үндэслэлээр хэргийг нь хүндрүүлэн зүйлчлэхгүй бөгөөд эрх зүйн байдлыг нь дээрдүүлсэн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зэргээр ялгагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлэх олон заалтыг дурьдаж болно. Харин шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн хэрэгжиж эхлэх хугацааг 2017 оны долдугаар сарын 01 болгож өөрчилснөөр одоо ял эдэлж буй хүмүүсийн ялыг шинэ Эрүүгийн хуульд нийцүүлж тэгшитгэх асуудал тодорхой хугацаанд хойшилж байна.

-Эрүүгийн хууль хэрэгжиж эхлэх хугацаандаа яагаад хэрэгжиж эхэлсэнгүй вэ. Хүмүүс их олон янзаар тайлбарлаад байна?

-Шинэчлэн найруулсан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиуд нь УИХ-ын чуулганаар хэлэлцэгдэж батлагдсан, хуульд заасан журмын дагуу ёсчлогдож “Төрийн мэдээллийн эмхэтгэл” сэтгүүлд нийтлэгдсэн, хүчин

болно”, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн долдугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт “Шүүх хүчин төгөлдөр болсон, албан ёсоор нийтлэгдсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ” гэсэн заалтын шаардлагууд хангагдаагүй бөгөөд процессын хуульгүйгээр шинэ Эрүү болон Зөрчлийн тухай хуулийг хэрэгжүүлэх боломжгүй юм. Шинэ Эрүүгийн хуулиар урьд нь захиргааны зөрчилд тооцогдож байсан зарим үйлдлүүд, түүний дотор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй хэмжээний хохиролтой хулгайн хэргүүд гэмт хэрэгт тооцогдох бөгөөд Эрүүгийн шүүхийн ачаалал тодорхой хэмжээнд нэмэгдэх болно. Мөн шүүхээс өмнөх буюу мөрдөн байцаалтын шатанд хүнийг хуульд заасан үндэслэлээр баривчлах, цагдан хорихоос гадна орон байранд нэвтрэх, үзлэг нэгжлэг хийх, эд зүйл хураан авах, битүүмжлэх, хууцаар мөрдөн шалгах гэх мэт хүний эрхэнд халдаж хийгдэх процесс ажиллагаанууд шүүхийн зөвшөөрлөөр хийгдэх ба шүүхийн байгууллагын хувьд энэхүү өсөн нэмэгдэх ачаалал, шинэ эрх зүйн орчинд тохирсон зохион байгуулалт, сургалт, хүний нөөцтэй холбоотой бэлтгэл хангагдаагүй байна. Хууль батлах, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах нь УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах бөгөөд өмнөх парламент бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө баталсан хуулийнхаа эцсийн найруулгыг хийж, ёсчлох боломжтой байсан боловч ажлаа дуусгалгүй чуулганыг завсарлуулсан. Цаашид УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, ийм тохиолдлыг хэрхэн шийдвэрлэхийг тодорхой болгох шаардлагатай гэдэг нь харагдаж байгаа.

-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хойшшлогдоод байгаа Эрүүгийн хуулиас салгаад дахин боловсруулаад яаралтай УИХ-д өргөн барихаар боллоо. Энэ гэр зөв алхам бэ?

-Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд анх удаа гэмт хэрэгт тооцож хуульчилсан. Мөн хүний амьнас, эрүүл мэндэд халдсан үйлдлүүд нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй бол хэргийг хүндрүүлэн зүйлчлэхээр заасан. Уг нь эдгээр багц хуулиуд нэгэн зэрэг батлагдаж, хэрэгжиж эхэлсэн бол илүү үр дүнтэй, зүйрлэвэл техникийн хувьд бүрэн бүтэн автомашинтай адил гацахгүй, хурдлах тусам инерци нэмэгдэж, тогтвортой үр нөлөөтэй ажиллах эрх зүйн орчин бүрдэх байсан. Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төр хүний эрх, эрх чөлөөг

хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасны дагуу ардчилсан нийгмийн үнэт зүйл болсон хүнийг эрхийг бодитой хангахад зөвхөн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль гэлтгүй шинэ Эрүүгийн багц хуулиудын хэрэгжилтийг аль болох цаг алдахгүй, яаравчлах шаардлагатай байгаа юм.

-Эрүүгийн хуулийг батлагдах үеэр хууль зүйн салбарт шинэ эргэлт авчрах болно гэж байсан. Ер нь энэ хуулийг шинэчлэн өөрчлөх болсон үндэслэл нь юу байв?

-Монгол Улсад маань нийгэм, эдийн засгийн харилцаа эрчимтэй хөгжиж, хүмүүсийн ахуй амьдралд гарч буй эерэг, сөрөг өөрчлөлтийг дагаад гэмт хэргийн нөхцөл байдал өөрчлөгдөж байна. Тиймээс ч гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой харилцааг зохицуулсан хуулиуд, түүнийг хэрэгжүүлэх шүүх, хуулийн байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг өнөөгийн хэрэгцээ шаардлага, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шинэчлэх хэрэгтэй болсон. Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлс, түүний дотор хүний эрх, шударга ёс, нийтийн эрх ашгийг бодитой, үр нөлөөтэй хамгаалах шаардлага бодитой бий болсон нь хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаа, шүүхийн шийдвэр хэрэгжилтийн байдалд хийсэн олон удаагийн судалгааны дүн, эрдэмтэн судлаачид, хуульчид, иргэд, улстөрчдийн санал, дүгнэлтээс тодорхой харагддаг. Өмнө нь тэр бүр шүүхээр хянан шийдвэрлэж байгаагүй, шинэ төрлийн гэж хэлж болох мөнгө угаах, хүн худалдаалах, хар тамхи мансууруулах бодис хууль бусаар борлуулах, нийгмийн аюулгүй байдалд галт зэвсэг хэрэглэн заналхийлэх, хуурамч төлбөрийн карт, цахим мэдээллийн сүлжээг ашиглан санхүүгийн луйвар хийх, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэх мэт зохион байгуулалттай үйлдэгддэг, үндэстэн дамнасан, хор уршиг ихтэй гэмт хэргүүд шүүхээр шийдвэрлэгдэх боллоо. Монгол Улсад эрүүгийн хариуцлагын тогтолцоонд хорих ял дийлэнх хувийг эзэлж, хорих ангиас суллагдсан хүмүүсийн дотор дахин гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлэх явдал өндөр хувьтай байна. Энэ нь ял шийтгэлийн хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зорилт хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байгаа хэрэг. Тиймээс

ч төрөөс ял шийтгэлийн талаар баримтлах бодлогоо эргэн харж, Эрүүгийн хуулийг шинэчлэх зайлшгүй шаардлагатай болсон гэж дүгнэж болно. Шинээр батлагдсан Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиас гадна гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, түүнийг илрүүлж, шалгаж, гэмт этгээдийг олж тогтоох, түүнд шударга ял оногдуулахад чиглэсэн процесс ажиллагааны стандартыг шинэчлэн тогтоож, өөрөөр хэлбэл хүний үндсэн эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл баримтлал бүхий Хууль сахиулах үйл

...Эрүүгийн хуульд шинээр орсон нэг чухал зохицуулалт бол ялгагдагчийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гэм буруугаа хүлээж, хохирлоо нөхөн төлсөн, эсвэл хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн хүнийг үйлдсэн гэмт хэргээс нь хамааран ялаас чөлөөлөх юм. Эсвэл ялыг хуульд зааснаас хөнгөрүүлэн оногдуулж болохыг хуульчилсан явдал юм. Ингэснээр гэм буруугаа хүлээсэн хүнд холбогдох хэргийг шүүх хялбаршуулсан шийдвэрлэх боломжтой болж байгаа...

ажиллагаа болон Гэмт хэрэг, зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулиуд батлагдаж, нэгэн зэрэг хэрэгжихгүйгээр бидний хүсэн хүлээсэн шинэчлэлийн үр дүн бодитой гарах болно.

-Эрүүгийн хуулийг өөрчлөн найруулснаараа ямар гол, гол өөрчлөлтүүдийг хийсэн юм бэ?

-Эрүү болон Зөрчлийн тухай хуулиуд нь нийгмийн бүхий л харилцаанд Монгол Улсын

Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг хамгаалж, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлдэг утгаараа яах аргагүй суурь хуулиудын нэг. Шинээр батлагдсан Эрүүгийн хуульд ардчилсан нийгмийн үнэт зүйлст халдсан гэм буруутай ямар үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохыг үйлдэл, гэм буруугийн хэлбэр, хор уршгийн шинжээр нь тодорхой заасан. Түүнчлэн Захиргааны хариуцлагын тухай хууль болон холбогдох 200 гаруй хуульд байсан хариуцлагын заалтуудыг Зөрчлийн тухай хуулиар төрөлжүүлэн нэгтгэж, тэдгээр зөрчлийг гаргасан хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн төрөл, хэмжээг нэгдсэн стандартад оруулсан нь Эрүүгийн хариуцлагын тогтолцоонд оруулсан гол өөрчлөлт гэж харж байна. Гэмт хэргийн ангиллаас ялын доод хэмжээ шууд хамаардаг, өөрөөр хэлбэл ялын хатуу хайрцаглагдсан бодлогоос татгалзаж, тодорхой төрлийн гэмт хэрэгт шүүхээс оногдуулж болох ялын төрлийг олон сонголттой болгосон. Ялын доод, дээд хэмжээний интервалыг сунгаснаар шүүх гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал, гэм буруутай хүний хувийн байдалд тохирсон ялыг сонгож оногдуулах боломж нэмэгдсэн. Эрүүгийн хариуцлага гэсэн хууль зүйн ойлголтыг ял, албадлагын арга хэмжээ болгон тодорхойлж, уламжлалт хорих, торгох ялаас гадна нийтэд тусгай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, эрх хасах зэрэг ялын төрлийг шинээр нэмсэн.

Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал зэрэг хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, давтан гэмт хэрэг үйлдсэн шинжээр хэргийг хүндрүүлэн зүйлчилдэг практикийг халж, үйлдсэн гэмт хэрэг тус бүрд нь тохирсон ял оногдуулдаг байхаар хуульчилсан нь ял шийтгэл гарцаагүй байх, үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон шударга байх зарчимд нийцсэн байгаа. Харин гэмт хэрэг байнга үйлдэж, түүнээс олсон орлогыг амьдралын эх үүсвэр болгосон, өөрөөр хэлбэл гэмт хэргийг өөрийн амьдралын зорилго, үндсэн ажил болгосон хүний хувьд холбогдох хэргийг хохирлын хэмжээнээс үл хамааран хүндрүүлэн зүйлчлэх тусгайлан зохицуулалт зарим өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт тусгагдсан юм. Гэмт хэргийн зүйлчлэл учирсан хохирлын хэмжээнээс шууд хамаардаг. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй дүйцүүлэн тооцсон бага бус, үлэмж, их, онц их гэсэн хохирлын хэмжээ нь хэргийн зүйлчлэл, ялын бодлогод шууд нөлөөлдөг

хамаарлыг өөрчилсөн байгаа. Зөвхөн их хэмжээний эсвэл ноцтой хохирол учруулсан тохиолдолд тодорхой төрлийн хэргүүдэд хэргийг хүндрүүлэн зүйлчлэхээр заасан. Хуульд заасан их хэмжээний хохирол нь 25 мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр илэрхийлэгдэх бол, ноцтой хохирол нь хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эдийн засгийн ач холбогдол бүхий эд хөрөнгийн эрхэд хохирол учирсан шинжээр тодорхойлогдох юм. Мөн торгох ял болон хохирлын хэмжээг тогтооход хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дүйцүүлэн тооцдог аргачлалыг өөрчилж, нэгж буюу одоогоор 2000 төгрөгтэй тэнцэх итгэлцүүрийг хуульчилсан. Учир нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хууль тогтоогч биш, харин Засгийн газар, ажил олгогч, үйлдвэрчний эвлэлийн гурвалсан хэлэлцээрээр тогтоох нь хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай адил хохирол, хэргийн зүйлчлэл, ялын хэмжээнд шууд нөлөөлж байгаа. Энэ нь хууль ёсны зарчимд нийцэхгүй гэж үзсэн тул шинэ Эрүүгийн хуульд төгрөгийн ханштай уясан нэгж гэдэг итгэлцүүрийг авсан бөгөөд нэгжийг өөрчлөх эрх хэмжээ зөвхөн УИХ-д хадгалагдах юм. Энэ мэт олон өөрчлөлтүүд бий.

-Шинэ Эрүүгийн хуульд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн тохиолдолд ял шийтгэлийн бодлого нь өөрчлөгдөхөөр тусгасан гэсэн үү?

-Эрүүгийн хуульд шинээр орсон нэг чухал зохицуулалт бол ялгагдагчийг шүүхэд шилжүүлэхээс өмнө гэм буруугаа хүлээж, хохирлоо нөхөн төлсөн, эсвэл хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн хүнийг үйлдсэн гэмт хэргээс нь хамааран ялаас чөлөөлөх юм. Эсвэл ялыг хуульд зааснаас хөнгөрүүлэн оногдуулж болохыг хуульчилсан явдал юм. Ингэснээр гэм буруугаа хүлээсэн хүнд холбогдох хэргийг шүүх хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой болж байгаа. Энэ нь ялтны эрх зүйн байдлыг дээрдүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цаг хугацаа, зардлыг хэмнэх сайн тайлгаас гадна энэ хэмжээгээр шүүхийн ачаалал багасах болно. Түүнчлэн бусдын эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг залилан авсан хүн авсан эд зүйлээ уг эд хөрөнгийг өмчлөгч, эзэмшигчид эргүүлэн өгсөн, бусад байдлаар эд хөрөнгийн эрхийг сэргээсэн бол залилах гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй гэж хуулийн холбогдох хэсэгт тайлбар хийсэн нь онцлог заалт юм.

ДЭЛХИЙ



Мирзияев Каримовыг залгамжлах уу

...Зарим шинжээчдийн хувьд Кариновын охидыг дараагийн Ерөнхийлөгч болох хүмүүсийн тоонд багтаадаг хэдий ч, бүс нутгийн хурцадмал байдлын голомт болсон Узбекистан улсыг түүний охид удирдах боломж бараг үгүй. Нэгэн үе том охин Гульнара Каримов дараагийн “титмийн эзэн” гэгдэж байсан ч, 2014 онд түүний замнал нь төгсч, гэрийн хорионд орсон гэх мэдээлэл бий...

Б.ДАВААХҮҮ

Хуучин ЗХУ нуран унаснаас хойш Узбекистан улсыг 25 жилийн турш удирдсан харгис дарангуйлагч Ислам Каримов таалал төгслөө. Үндсэндээ өнгөрсөн долоо хоногоос эхлэн түүнийг таалал төгссөн байж болзошгүй гэх мэдээлэл сайтуудаар цацагдаж эхэлсэн бөгөөд түүний охин Лола Каримова Тилляева инстаграмм хуудастаа эцгээ тархиндаа цус харвасныг нотлосон нь эхний дуулианыг дэвэргэж орхисон юм. Харин Засгийн газрын албаны эх сурвалж өнгөргөгч баасан гарагийн оройн 20.00 цагт Ислам Каримов 78 насандаа тэнгэрт хальсныг зарласнаар Укбекистаны харгис дарангуйлагчийн эрин үе дуусч

буй нь нэгэнт ойлгомжтой боллоо. Узбекистан улсын Ерөнхийлөгч Ислам Каримов агсныг эцсийн замд нь үдэх ёслолынажиллагаабямбагарагт тун зохион байгуулалттай болж өндөрлөсөн. Оршуулгын ёслолын төв телевизээр шууд дамжуулан үзүүлсэн бөгөөд нийслэл Ташкент хотын эмнэлгээс Самаркандын ЮНЕСКО-ын дэлхийн өвд бүртгэгдсэн цэнхэр өнгийн бөмбөлгөн оройтой Регистаны талбай хүртэл Узбекистаны удирдагчийн оршуулгын цуваа үргэлжилсэн байна. Зөвлөлт холбоот улсад багтаж байсан төв Азийн таван улсын дундаас хамгийн увайгүй, дарангуйлагч гэгддэг байсан Ислам Каримовыг ээж, ахынх нь хажууд нутаглуулжээ. Энэхүү оршуулгын ёслолд Афганистаны Ерөнхийлөгч Ашрап Гани нарын хөрш орны удирдагчид оролцсон байна.

ЗХУ нуран унаснаас хойш 25 жилийн турш тусгаар тогтносон Укбекистан улсыг удирдсан Каримов эрх мэдлээ ийнхүү удаан хадгалж ирсэн нь урьдаас тооцож боловсруулсан зохион байгуулалттай сонгууль байсан гэдэг.1991 ондЕрөнхийлөгчөөр томилогдсоны дараа 1996 онд бүх нийтийн санал асуулгаар тэрээр 2000 он хүртэл албан тушаалаа хадгалж үлдэх эрхтэй болж байв. Харин 2000 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хүч үзэж, 91.9 хувиар ялж байлаа. Тухайн үед АНУ “Узбекистаны сонгуульд шударга, чөлөөт байдлын аль аль нь алдагдсан” гэдгийг шүүмжилж байсан удаатай. Өнгөрсөн жил ч гэсэн тэрээр 90 хувийн саналаар ялж байсан юм. ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнуудын хамгийн харгис нь гэж түүнийг тодотгосон нь учиртай. Түүнийг амьд сэрүүн ахуйд үе үе дэлхий нийтийн цочроосон аймшигт харгислалын хэргүүд ар араасаа гарч байлаа. Хамгийн аймшигтай нь 2002 онд Каримов хоригдлуудыг амьдаар нь чанасан явдал байв. Гэхдээ Афганистантайхиллэдэг,лалын гол улсын нэг Узбекистаныг лалын ариун дайчдын тэмдлээс хатуу гарын дор хамгаалж

ирсэн нь түүний гавьяа байсан гэдэгтэй хэн ч маргахгүй. Үнэндээ 32 сая хүн амтай, манай улсаас гурав дахин бага нутагт орших лалын шашны үзэл санаа хүчтэй нөлөөтэй, угийн дайнч ард түмнийг одоо хэн удирдах, тэр нь Каримовын дайтай ажиллаж чадах эсэх нь тун эргэлзээтэй болж байна. Гэхдээ зарим ажиглагчдын үзэж буйгаар Ислам Каримовыг залгамжлах хамгийн боломжит гурван хувилбар бий аж. Тодруулбал, Ерөнхий сайд Шавкат Мирзияев, түүний орлогч бөгөөд Сангийн сайд Рустам Азимов, 1995 оноос хойш тус улсын Үндэсний Аюулгүй байдлын албыг толгойлж буй Рустам Иноятов нарыг нэрлэж байна. Гэхдээ тэднээс хамгийн магадлал өндөртэй нь Мирзияев. Түүний хувьд 2003 оноос хойш Засгийн газрыг тэргүүлж байгаа. Өмнө нь тэрбээр 2001-2003 онд Самаркандын засаг дарга, 1996-2001 онд Жиззикын засаг даргаар ажиллаж байв. Хэрэв тэр Ерөнхийлөгч болбол Засгийн газар одоогийнхоос ч илүү дарангуйллын хэлбэрт шилжиж магадгүй гэнэ. Мирзияев удирдагчийн гэр бүлтэй ойроос гадна Оросын сонирхолд хамгийн их нийцдэг хүн гэгддэг.

Харин өөр нэг хувилбар нь Ерөнхий сайдын орлогч бөгөөд Сангийн сайд Рустам Азимов. Ташкентаас гаралтай түүний хувьд 1998 оноос хойш Засгийн газарт зүтгэх болжээ. Санхүүгийн салбарт тун туршлагатай нэгэн гэж үзэж болно. Узбекистан тусгаар тогтносноос хойш буюу 1992 оноос Үндэсний банкны Гадаад үйл ажиллагаа хариуцсан даргаар ажиллаж байсан тэрбээр Каримовын том охин Гульнаратай нягт хамтран ажиллаж, олон улсын гэрээ хэлцэл, гадаадын банкинд мөнгө төвлөрүүлэх зэрэг үйлсэд нь тусалж байсан гэдэг. Узбекистаны ажиглагчдын үзэж буйгаар Рустам Азимов Барууны орнуудтай харилцах туршлага талаасаа одоогийн Ерөнхий сайдаас ч илүү оновчтой сонголт байж болох талтайг онцолж байна. Гурав

дахь хувилбар бол Үндэсний аюулгүй байдлын албаны дарга Рустом Иноятов. Түүний хувьд одоогийн албан тушаалаа 1995 оноос хойш хашиж ирсэн. Гэхдээ эхний хоёр хувилбарыг бодвол дэмжигчид бараг үгүй гэж хэлж болно.

Тиймээс дараагийн Ерөнхийлөгч болох боломж тун бага. Зарим шинжээчдийн хувьд Кариновын охидыг дараагийн Ерөнхийлөгч болох хүмүүсийн тоонд багтаадаг хэдий ч, бүс нутгийн хурцадмал байдлын голомт болсон Узбекистан улсыг түүний охид удирдах боломж бараг үгүй. Нэгэн үе том охин Гульнара Каримов дараагийн “титмийн эзэн” гэгдэж байсан ч, 2014 онд түүний замнал нь төгсч, гэрийн хорионд орсон гэх мэдээлэл бий. Ямартай ч, бүс нутгийн гол түшиц газар болсон Узбекистан улсын Ерөнхийлөгч таалал төгсөхтэй зэрэгцэн түүнийг хэн залгамжлах нь дэлхийн хэвлэл мэдээллийн анхаарлыг татаж эхэллээ.

Н.Моди Вьетнамд 500 тэрбум ам.доллар зээллээ

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моди Вьетнамд айлчиллаа. Вьетнамын Ханой хотноо хийсэн уулзалтын дараа тэрбээр хоёр улсын Батлан ​​хамгаалах харилцааг бэхжүүлэх зорилгоор Энэтхэг улс Вьетнамд 500 мянган ам.доллар зээлэхээр болсноо албан ёсоор зарласан байна. Өмнөд Хятадын тэнгис дэх эзэмшил бүстэй холбоотой асуудлаар Хятад, Вьетнам хоёр улс маргаантай байдаг. Гэвчсүүлийн үедХятадөөрийн эзэмшил бүсэдхүндзэвсэгтехникийг байрлуулж, хяналтаа чангатгах болсноор тухайн хэсгийн байдал хурцдаж эхэлсэн. Тэгвэл Наренда Модигийн энэ удаа Вьетнамд олгож буй зээл Өмнөд Хятадын тэнгист зэр зэвсгээ гайхуулах Хятадыг эсэргүүцэх зорилготой гэж зарим эх сурвалж харж байна. Энэтхэгийн Ерөнхий сайдын хувьд зээлийн зориулалтын талаар дэлгэрэнгүй тайлбар хийгээгүй. Гэхдээ энэ хэрийн хөрөнгийг зээлснээр цаашдаа Вьетнамын Засгийн газар Энэтхэгийн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ хийх үүрэгтэй гэнэ.

“Шүхэрт хувьсгал”-аас хойшхи анхны сонгууль Хонконгод болов

Хонконгод өчигдөр дэлхий дахинаа “Шүхэрт хувьсгал” хэмээн алдаршсан оюутнуудын эсэргүүцлийн хөдөлгөөнөөс хойшхи анхны парламентын сонгууль зохион байгуулагдлаа. Сонгуулийн санал хураалт орон даяар өглөөний 07.00цагт эхэлж, 22.00цагт өндөрлөсөн бөгөөд үүнээс хойш санал тооллогын үйл ажиллагаа албан ёсоор эхэлсэн байна. Харин сонгуулийн дүн өнөөдөр гэхэд тодорхой болох аж. Хууль тогтоох байгууллага хэдийгээр 70 суудалтай ч, сонгогчдын хувьд тойргоо төлөөлөх нийтдээ 35 хүнийг сонгох ёстой. Мөн хүн бүр саналаа өгөх боломжгүй. Тодруулбал, нийт хүн амын ердөө зургаан хувь нь л дээрх 30 суудалд хэн томилогдохыг шийддэг гэсэн үг. Ерөнхийдөө Хонконгод сонгуулийн насны 3.7 сая сонгогч байдаг ч, 239724хүн сонгуульд саналаа өгнө. Мөн сонгогчид гүйцэтгэх засаглалын тэргүүнээ сонгодоггүй. 2014 онд хоёр сарын турш оюутнууд тэргүүтэй жагсагчид Бээжингээс гүйцэтгэх засаглалын тэргүүнийг шууд сонгодог байдлыг эсэргүүцэн жагсч байсан юм. Тэр сонгуулиас хойшхи анхны сонгууль өчигдөр болж буй нь энэ. Зарим эх сурвалжийн мэдээлснээр, БНХАУ-ын талыг баримтлагч хууль тогтоогчид дахиад олонх болох магадлал өндөр байна.

Тайландын хаан эмнэлэгт хэвтжээ

Тайландын хаан Пумпипон Адульдет нийслэл Бангкок хотын нэгэн эмнэлэгт хэвтэн эмчилгээ хийлгүүлж байгаа тухай тус улсын Хааны ордон мэдэгдлээ. Хаан ширээнд хамгийн удаа сууж буй Пумпипон Адульдетын амьсгал сүүлийн үед давхцах болж, цусны даралт нь буурч, бөөрний үйл ажиллагаа нь хэвийн бүс болжээ. Эдүгээ 88 настай хаан Пумпипон сүүлийн саруудад нэг бүс удаа эмнэлэгт хэвтсэн юм. Өнгөрсөн онд тэрбээр цөсөө авахуулах хагалгаанд орсон. Тайландын хувьд түүний эрүүл мэндийн асуудал сүүлийн жилүүдэд түгшүүртэй асуудлуудын нэг болоод байна. Түүнийг хэн залгамжлах нь тодорхойгүй байгаа юм. Тэрбээр сүүлийн таван жилийн дийлэнх хугацааг эмнэлэгт өнгөрүүлсэн билээ.

ЭМГЭНЭЛ



Хомборын Эрдэнэ /1958-2016/

Монголын Төмөр Замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Төр овогтой Хомборын Эрдэнэ 2016 оны наймдугаар сарын 31-ний өдөр таалал төгссөнд түүний үр хүүхэд, төрөл төрөгсөд болон зам, тээврийн салбарт нөхөж баршгүй гарз тохиолоо. Х.Эрдэнэ нь төмөр замын хөгжил дэвшил болонийтхөдөлмөрчдийнхөөажиламьдралын төлөө Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын үйл ажиллагааг идэвхижүүлэх, нийгмийн түншлэлийг хөгжүүлэн төгөлдөржүүлэхэд бүхий л сэтгэл зүрхээ зориулсан бүтээлч нэгэн байлаа. Х.Эрдэнэ нь 1958 онд Увс аймгийн Өмнөговь сумын нутагт төрж, Ерөнхий боловсролын сургууль дүүргэн, Төмөр замын техникумд элсэж төмөр замын салбарт ажил, амьдралаа холбосон юм. 1978 онд Вагоны техникч, механикч мэргэжил эзэмшиж, Улаанбаатар төмөр замын суудлын вагон депод засварчин, Монголын Хувьсгалт залуучуудын эвлэлийн хорооны даргаар ажиллаж байгаад Төр нийгэм судлалын академийг Улс төр судлаач, нийгэм эдийн засгийн мэргэжлээр төгссөн. Улмаар Улаанбаатар төмөр замын суудлын вагон депод мастер, галт тэрэгний дарга, 2004 оноос тус депогийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны даргаар тус тус ажиллаж байсан. 2011 оноос Монголын Төмөр замчдын Үйлдвэрчний эвлэлийн холбооны даргаар сонгогдон ажилласан юм.

Тэрээр ажиллах хугацаандаа Монгол Улсын Засгийн газар, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн холбооны хөдөлмөр нийгмийн зөвшөлийн үндэсний хорооны гишүүн, Хөдөлмөр аюулгүй байдал Эрүүл ахуйн үндэсний зөвлөлийн гишүүн, Олон улсын тээврийн ажилчдын холбооны Ази номхон далайн бүсийн төмөр зам хариуцсан дэд Ерөнхийлөгч, Монгол Оросын хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр нийгэмлэгийн Ерөнхий хорооны гишүүнээр тус тус сонгогдож, тодорхой санал санаачилгуудыг гарган идэвхитэй ажиллаж байлаа. Мөн Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар Төмөр Замын нийт ажилчдын нийгмийн асуудлуудын хууэнд хамтын гэрээгээр төмөр замчдын талархлыг хүлэсэн олон чухал асуудлуудыг шийдвэрлүүлж байсан. Х.Эрдэнийн хөдөлмөр бүтээлийг үнэлж төр засгийн дээд шагнал Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугын одон, Алтан гадас одон, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны “Хөдөлмөрийн хүний төлөө” цол тэмдэг, Хүндэт төмөр замчин, Тэргүүний төмөр замчин цол тэмдэгээр тус тус шагнасан байна. Мөн МҮЭ-ийн холбооны 19, 20, 21-р их хурлуудад төлөөлөгчөөр сонгогдон МҮЭ-ийн холбооны Ерөнхий зөвлөлийн гишүүн, тэргүүлэгчээр тус бүр хоёр удаа сонгогдон ажиллаж байлаа.

Талийгаачийн гэгээн дүр, ажил амьдралын үйлс бүтээл, итгэл зүтгэлийн гэгээн зам балрахгүйгээр бидний зүрх сэтгэлд үүрд мөнхрөн дурсагдах болно.

Ум сайн амгалан болтугай.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

ШУУРХАЙ МЭДЭЭ

ОЮУТНУУД 3600 ТӨГРӨГ ТӨЛӨӨД САРДАА 44 УДАА АВТОБУСАНД ҮНЭГҮЙ ЗОРЧИНО

Б.ДАВАА

“Улаанбаатар смaрт карт” ХХК-ийн Үйл ажиллагааны хэлтэс, тээврийн хэсгийн ахлах менежер Ц.Түвшинжаргалаас зарим зүйлийг тодрууллаа.

-Оюутнуудын нийтийн тээврээр үнэгүй зорчих хөнгөлөлттэй картын захиалга болон сунгалтын талаар тодруулаач?

-Сунгалт, шинээр олголтын ажил тухайн их, дээд сургуулиар дамжуулаад хийгдэнэ. Тэгэхээр оюутнууд шинээр карт захиалах болон сунгуулах хүсэлтээ сургуулийнхаа захиргаанд гаргах ёстой. Сунгуулах оюутнуудын тухайд ашиглаж байсан картаа хураалгана. Хураасан картанд нэгдсэн байдлаар сунгалт хийгдэж, оюутнуудад дахин олголт хийгдэх юм. Энэ ажлыг Улаанбаатар смaрт карт компани зохион байгуулна. Хариншинээрзахиалахгэжбуйоюутнуудсургуулийнхаа захиргаанд хандан маягтаа бөглөж, захиална.

-Картын хураамж хэд байх вэ?

-Шинээр захиалах бол 3600 төгрөг. Харин сунгалт хийлгэхэд 1000 төгрөг байгаа.

-Сунгалт 1000 төгрөг гэлээ. Арай үнэтэй биш үү?

-Энэ шийдвэрийг холбогдох байгууллагууд хуралдаж, гарах зардлыг тооцон оюутанд хүндрэлгүй байхаар тооцоолж хийсэн. Ерөнхийдөө автобусанд хоёр удаа зорчих мөнгө шүү дээ.

-Шууд автоматаар сунгах боломжгүй юм уу?

-Автомат цэнэглэлт нь сар бүрийн 1-ний өдөр хийгддэг. Карт дээр нь тухайн картын ашиглах хугацааг сунгаж өгсөн байдаг. Есдүгээр сарын 1-нээс зургадугаар сарын 30 хүртэл. Картын хугацааг сунгахдаа заавал автомат төхөөрөмжид уншуулж байж сунгах шаардлагатай. Автоматаар сэргээх боломжгүй. Сурч байгаад дундаас нь гарсан, чөлөө авсан, төгссөн гэх мэт оюутнууд байдаг учир шууд нэгдсэн байдлаар сунгах боломжгүй.

-Оюутнууд нийтийн тээврээр зорчих хөнгөлөлттэй картаа хэзээ авах вэ?

-Нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих картын захиалга болон сунгалт хийлгэх хүсэлтийг наймдугаар сарын 31-нээс энэ сарын 6-ны өдрийг дуустал сургуулиуд дээр хүлээн авна. Есдүгээр сарын 12-ны өдрөөс 18-ны өдрүүдэд хөнгөлөлттэй картыг сургуулиудаар нь дамжуулан тараана.

-Нийтийн тээврээр хөнгөлөлттэй зорчих картаа оюутнууд хичээлийн эхний өдрөөс авчихдаг. Энэ жил захиалга яагаад хойшлов?

-Бүх оюутнуудыг хөнгөлөлттэй картын захиалгад хамруулахын тулд наймдугаар сарын 31-ний өдрөөс захиалгыг эхлүүлээ. Өөрөөр хэлбэл, бүх оюутнууд элсэж дууссаны дараа захиалгыг албан ёсоор эхлүүлсэн.

-Оюутнууд нийтийн тээврийн хөнгөлөлттэй картаараа 44 удаа зорчдог. Энэ журамд өөрчлөлт орсон уу. Оюутнууд автобусаар зорчих төлбөрийнхөө 50 хувийг өөрсдөө даана гэсэн мэдээлт байсан?

-Улсаас оюутнуудын смaрт картыг 44 удаа зорчих эрхээр цэнэглэж өгдөг байгаа. Одоогоор энэ журамд өөрчлөгдсөн зүйл байхгүй. Хөнгөлөлттэй зорчиж байгаа оюутны картын нөхөн олговрыг нийслэлийнтөсвөөстээвэрлэсэн аж ахуйн нэгжүүдэд олгодог.

Үүний дагуу квотыг ИТХ-аар баталсан журмын дагуу тогтоодог. Одоогоор журамд өөрчлөлт орсон талаархи мэдээлэл манайд ирээгүй байгаа. Өнгөрсөн жилийн батлагдсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

-Картыг хэчнээн оюутанд олгоно гэж тооцоолсон бэ?

-Өнгөрсөн жил их, дээд сургуулийн 57 орчим мянга, МСҮТ, коллежийн 12 мянган орчим оюутанд карт олгогдож байсан. Сургуулиуд төрийн байгууллагаас тогтоосон хяналтын тоонд багтаан шинээр карт авах оюутнуудын мэдээллийг хянаж баталгаажуулан ирүүлснийг үндэслэн их, дээд сургуулиудад нийслэлийн Боловсролын газар, МСҮТ, Коллежуудад нийслэлийн Хөдөлмөрийн газар шинээр олголт хийнэ.

-Энэ жил төгссөн оюутнуудын хувьд автобусны хөнгөлөлттэй картаа дахин ашиглах боломж бий юу?

-Өнгөрсөн жил хөнгөлөлттэй картаар автобусанд зорчиж байгаад сургуулиа төгссөн хүмүүсийн хувьд ашиглаж байсан картаа дахин ашиглах боломжтой. Гэхдээ хөнгөлөлттэй зорчих карт нь энгийн картын горимд шилжсэн. Тиймээс энгийн карттай адил тогтмол цэнэглэн ашиглах боломжтой.

Баянзүрхийн товчоог нүүлгэнэ

Н.БАТЗАЯА

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат амралтын өдрүүдэд салбарынхаа зарим газартай биечлэн танилцаж, шийдвэрлэх шаардлагатай асуудлыг анхааралдаа авч ажиллаж байгаа билээ. Тэгвэл тэрбээр өнгөрсөн бямба гарагт Баянзүрх товчооны үйл ажиллагаатай танилцлаа. Түүнийг нийслэлийн Засаг даргын Ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан болон албаны бусад хүмүүс хүлээн авч нөхцөл байдлын талаар танилцуулж, санал хүсэлтээ уламжилсан. Тус товчоо нь анх хотын захад байсан ч хот тэлэхийн хэрээр суурьшлын бүсэд хамаарагдах болжээ. Одоогийн байдлаар Баянзүрх товчоонд малын гоц халдварт өвчин гарсантай холбогдуулан ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил хийгдэж байгаа юм. Хотын суурьшлын бүсэд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажил хийх нь хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бөгөөд цаашилбал халдварт өвчин хотод орж ирэх магадлалтай учраас Баянзүрхийн товчоог “Налайхын IV дүгээр зөрлөг” буюу Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах Шалган бүртгэх товчоонд шилжүүлэх хэрэгтэй гэдгийг мэргэжилтнүүд хэлж байлаа. Үүний дараа салбарын сайд Д.Ганбат өөрийн биеэр “Налайхын IV дүгээр зөрлөг”-т байрлах шалган бүртгэх товчооны үйл ажиллагаатай танилцсан юм.

Тэрбээр энэ үеэр “Баянзүрхий товчоо нэгэнт хотын суурьшлын бүсэд орсон учир Налайхын IV дүгээр зөрлөг” буюу Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах Шалган бүртгэх товчоонд шилжүүлэх нь зүйтэй. Үүний тулд мэргэжлийн байгууллагуудыг нэг дор төвлөрүүлэн ажиллуулах нөхцөл бололцоог хангаж, энэхүү үйл ажиллагааг цэгцлэх ажлыг яаралтай зохион байгуулах шаардлагатай.

Малын гоц халдварт өвчин ойр ойрхон гарч байгаа энэ үед халдваргүйжүүлэлтийн үйл ажиллагааг суурьшлийн бүсээс нүүлгэн шилжүүлэх нь маш чухал асуудал юм. Нэгэнт Засгийн газрын тогтоол гарсан тул энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд Онцгой байдал, Мал эмнэлэг, Мэргэжлийн хяналт, Цагдаагийн газар, Зам тээврийн хөгжлийн төв зэрэг байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийг яаралтай байгуулна” гэв. Энэхүү халдваргүйжүүлэх үйл ажиллагааг суурьшлийн бүсээс холдуулахын тулд Зам, тээврийн хөгжлийн яамнаас УБ хотын удирдлагууд болон Онцгой байдал, Мэргэжлийн хяналт зэрэг байгууллагуудтай хамтран товчоог нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авахаар боллоо.

СЭРЭМЖЛҮҮЛЭГ

ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ СИНГАПУРТ ЗОРЧИХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛЛАА

Сингапур улсад “Зика” вирусын тархалт эрс нэмэгдэж, өвчлөгсдийн тоо 115-д хүрсэнтэй холбогдуулан хөрш зэргэлдээ улсууд болох Индонез, Малайзад өндөржүүлсэн хяналт тогтоож, олон улсын нисэх буудлуудад гаднаас ирж буй зорчигчдын халууныг шалгах зэрэг арга хэмжээ авч эхлээд байна. “Зика” вирусын анхны тохиолдол Малайз улсад энэ сарын 1-нд бүртгэгдэж, Индонезийн нэг иргэн мөн өвчилсөн тухай Сингапурын Эрүүл мэндийн яамнаас мэдэгдсэн тул манай иргэд, ялангуяа жирэмсэн эмэгтэйчүүд онц шаардлагагүй бол Сингапур болон хөрш зэргэлдээ бусад орнуудад нь зорчихгүй байх, эдгээр улсад зорчих иргэд тухайн улсын холбогдох байгууллагаас гаргасан анхааруулга, сэрэмжлүүлгийг дагаж мөрдөн сонор сэрэмжтэй байхыг Гадаад хэргийн яамны Консулын газраас анхаарууллаа.

Зарим сумд ургацаа бүрэн алджээ



Хэнтий аймгийн хэмжээнд зуншлага тааруу, таримал ургамлын бутлалтаас гол хатгалтын хүртэлх хугацаанд чийгийн дутагдал болон хэт их халалтаас шалтгаалан Дадал, Норовлин, Батноров сум ургац бүрэн алджээ. Хэрлэн сумын Өлзийт тосгон, Өмнөдэлгэр сумын Хурх тосгоны зарим аж хуйн нэгжүүд нийт 14,2 мянган га талбайн ургацаа алдсан байна.

Тус аймгийн хэмжээнд газар тариалангийн 90.2 мянган га-д эргэлтийн талбайтай, үүнээс 67.2 мянган га талбайг аж

ахуйн нэгж эзэмшдэг. Энэ онд 42 аж ахуйн нэгж иргэд нийт 33.6 мянган га-д тариалалт хийснээс үр тариа 24.7 мян/га, малын тэжээл 605 га, тосны ургамал 7.3 мян/га-д төмс, хүнсний ногоо 700 гаруй га-д тус тус тариалжээ. Мөн энэ жил 29.6 мянган тн үр тариа хураан авахаас аймгийн ургац тогтоолтын урьдчилсандүнгээр 10.6 мянган тн буюу нэгжээс 6.7 цн ургац хураан авах төлөвтэй, энэ нь нийт хураах ургацынхаа 35.8 хувийг хураан авч 64.2 орчим хувийн ургацаа алдах төлөв байдалтай байгаа аж.

PHOTO NEWS



Гэрэл зургийг Г.АРТУУЖИН

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэтцэх тухай хуулийг 12 жилийн дараа шинэчлэн, өнгөрсөн хаваф батласан. Энэ хууль нь одоо чуулганаар хэлэлцээд буй Эрүүгийн болон Зөрчлийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиудтай нягт уялдаатайгаар хуульчлагдсан бөгөөд энэ сарын 1-нээс хэрэгжиж эхлэхээр байсан. Гэвч МАН-ын Засгийн газар уг хуулийг эгүүлэн татсанаар олон нийтийн эсэргүүцэлтэй тулгафад байна. Тэгвэл тус шийдвэрийг эсгүүцэн эргүүлэн батлахыг шаардаж Нээлттэй Ардчилсан нам Шинэчлэлийн нэгдсэн хөдөлгөөнөөс өнгөргөч бямба гарагт “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д лаа асаан тэмцлээ.

Тэтгэлэгт хамрагдах хүсэлт шинээр авахгүй

Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд Гадаадын их, дээд сургуульд суралцагчдын тэтгэлэгт хөтөлбөрийг зогсоох талаар тусгажээ. Тодруулбал, гадаадын тэтгэлэгт хөтөлбөрт 2016-2019 онд шинээр оюутан хамруулахгүй байх, цаашид зээлийн эргэн төлөлтийн хэмжээнд тохируулан хамрагдах оюутны тоог

тогтоохоор болсон байна. Гадаадын их, дээд сургуульд суралцагчдын тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2016 онд Засгийн газар хоорондын гэрээгээр 7.3 тэрбум төгрөг, дэлхийн шилдэг 100 сургуульд 11.5 тэрбум төгрөг бусад арга хэмжээнд 4.5 тэрбум төгрөг нийт 33.1 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд улсын төсвийн боломжтой

уялдуулан энэхүү хөтөлбөрийг одоогийн батлагдсан зардлын хэмжээнд үргэлжлүүлэх буюу зардал нэмэгдүүлэхгүй байхаар шийдвэрлэжээ. Ингэхдээ гадаадад тэтгэлэгт хамрагдах хүсэлтийг шинээр хүлээж авахгүй харин хуучин тэтгэлгээр суралцаж байгаа оюутнуудыг үргэлжлүүлэн суралцуулах бодлого барих аж.

Цэргийн сургуулилтад 1000 орчим цэрэг оролцлоо

“Сэлэнгэ-2016” цэргийн хээрийн сургуулилалтын хүрээнд Орос, Монголын цэргийнхэн хамтран бэлтгэл хийсэн байна. ОХУ-ын Дорнод цэргийн тойргийн хэвлэлийн албаны дарга Александр Гордеевын мэдээлснээр, “Бурдуны” хээрийн сургуулилалтын талбайд хоёр орны цэргийн анги нэгтгэл хооронд холбоо тогтоох асуудлууд,

тактикийн бүлгүүдийн үйл ажиллагаа явуулах маршрутыг боловсруулсан байна. Оросын талаас танкийн батальон, мотоциууддагын рот, мина харвагчийн өөрөө явагч их буу, тийрэлтэт артиллерийн батарей, агаарындовтолгооноос хамгаалах, тагнуул болон радиад, хими, биологийн анги нэгтгэл оролцов. Монголын талаас БМП болон БТР-ийн мотоциууддагын ротууд,

танкийн анги нэгтгэл, мина харвагч болон тийрэлтэт артиллерийн батарей оролцжээ. Сургуулилалтад хоёр талаас 1000 орчим цэрэг, ойролцоогоор 200 нэгж цэргийн техник, тэгдээрийн дотор Оросын Дорнод цэргийн тойргийн нисэс онгоцууд оролцсон байна. Орос, Монголын цэргийн “Сэлэнгэ” сургуулилалтыг 2008 оноос хойш жил бүр зохион байгуулж байгаа юм.



Сумын сургуулийн багачууд



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Улаанбаатарт:



Маргааш
Өдөр 16
Шөнө 5



Нөгөөдөр
Өдөр 17
Шөнө 5

Өдрийн зурхай

Намрын дунд улаагчин тахиа сарын Хоёр хар мэнгэтэй Цагаан бар өдөр. Сумъяа гараг



Өдрийн өнгө: Тухайн өдөр торь, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Эл өдөр архи уух, талхи татах, сэтгэл муутантай нохорлох зэргийг цээрлэх хэрэгтэй ба хараал, жатхыг буцаах, амьлуулах, өглөгийн түлээг хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, болбын үйл, бэрийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод хойш төрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний, хүч сайжирна.

Бидэнд тохиолдсон



Оюунсайханы Баярцэцэг

Манай нөхөр хоолноос манжинг нь ялгангаа үглэж байна. Заваан манжин яах гэж хийдэг юм. Ядаргаатай үүнийг нь идэхээр гэдэс гүйлгээд байх юм гээд л үглэж гарав. Би дотроо манжин идэхээр гэдэс гүйлгэнэ гэж юу байх вэ дээ. Худлаа маяглаад. Маргааш хоолондоо мэдэгдэхгүй болгоод хийчихээр идэж л таарна гэж бодов. Маргааш нь манжингаа жижигхэн гэгч нь хэрчээд, мэдэгдэхгүй болтол нь шарж, хуурч амтлан нөхөртөө өглөө шүү. Тэгсэн нөхөр маань сайхан амттайг нь гайхаад л идэж орхилоо. Хоолны дараа би аяга угаах байхдаа “Манжин манжин гээд л үхэх гээд байдаг. Мэдэхгүй идчихлээ шүү” гэж бодоод зогсож байтал нөхөр ариун цэврийн өрөөнөөс гарч ирээд “Ёо яг манжин идсэн юм шиг нэг их эвгүй гүйлгээд байх юм” гэдэг юм даа. Би гаднаа өө байал юм гэсэн мөртлөө дотроо үнэнээсээ манжин идэхээр гүйлгэдэг юм байна гэсэн дүгнэлт хийсэн юм даа.

Лхагваа Батболд

Манай хуучин ажлын эгч хааяа нэг таарахаараа л “Пээх яасан их таргалаа вэ. Яасан их тураа вэ, ямар царай алдаа вэ” гээд л гоочлоод байдаг байв. Тэгсэн саяхан нөгөө эгчтэйгээ таарав аа. Эгч өөрөө нэлээд дэлбэрсэн байна шүү. Тэгснээ “Чи бид хоёроос бусад нь мисс ээ мисс” гэдэг байгаа. Хаха бас хань татаастай. Хүмүүс нээрээ яагаад ийм лаг юм бэ.

ХОЛЛИВУДЫН СОНИН ХАЧИН



Сильвестр Сталлоне АМЬД

Б.ДАВАА

Өнгөргөч долоо хоногт “Рокки Бальбоа” киногоороо манай үзэгчдэд танигдсан Сильвестр Сталлоне өвчний улмаас таалал төгсчээ гэх мэдээлэл түүний зургийн хамт сошиал сүлжээгээр тарж, фэнүүдийг нь уйлахад хүргэжээ. Тэгвэл тэрхүү “эмгэнэлт” зургийн учир тайлагдсан гэнэ. Америкийн жүжигчин, найруулагч зохиолч эдүгээ 70 настай Сильвестр Сталлоне амьд мэнд байгаа төдийгүй өөрийн инстаграмм хуудастаа Сергей Ковалёвын хамт авахуулсан зургаа нийтэлж, гэжээ дүрээрээ шүтэн бишрэгчидтэйгээ мэндчилсэн аж. Тэрбээр “Хүнд жингийн аварга, хүчирхэг Сергей Ковалевтай” гэх тайлбарыг зүүсэн байв. Кино урлагийн хамгийн том Оскарын наадамд хоёр ч удаа нэр дэвшиж байсан жүжигчин залуу ийнхүү мэндчилсэнээр цахимаар “хүн үхүүлдэг” багийнхны сүүлчийн хохирогч болсон нь олон нийтэд ил болсон байна. “Рокки”, “Рэмбо” дурийнх нь үнэнч шүтэн бишрэгчдийн хувьд сошиал сүлжээгээр цацагдсан мэдээллийн улмаас шоконд ороод байжээ. Уг хуурамч мэдээллийг АНУ-ын CNN агентлаг фэйсбүүк хуудастаа нийтэлж, улмаар тэрхүү мэдээлэл нь фэйсбүүк сүлжээнд идэвхтэй тарсан нь тэр ажээ.

ДУУЛГАХ СОНИН

Г.Отгонцэцэг ЭХ ОРОНДОО ирлээ

Рио-2016 олимпын наадамд Казахстан улсын нэрийн өмнөөс оролцож, жүдо бөхийн 48 кг-ын жинд хүрэл медаль хүртсэн Г.Отгонцэцэг эх орондоо ирлээ. “Рио-2016” олимпын жүдо бөхийн эмэгтэйчүүдийн 48 кг-д Казахстан улсын нэрийн өмнөөс оролцож, хүрэл медаль авсан тэрбээр дасгалжуулагч Д.Энхбаатарын хамт бямба гарагт эх орондоо ирсэн байна. Тамирчин бүсгүй олимпын наадамд оролцох хүслээ биелүүлэхийн тулд Казахстан улсын нэрийн өмнөөс барилдах шийдвэр гаргасан байдаг. Тэр мөрөөдлөө ч биелүүлж, олимпын хүрэл медальтан болсон билээ. Г.Отгонцэцэг эхний тойрогтоо Т.Лимаг ялсан ч хэсгийн аваргын төлөөх барилдаанд дэлхийн аварга, Японы жүдоч А.Кондод ялагдсан. Улмаар дагах тойрогт Унгарын Ч.Эваг, хүрэл медалийн төлөөх барилдаанд Кубийн Д.Алваресыг ялж, хүрэл медаль хүртсэн юм.



Аадар багын анд Цэнгэлийнхээ дуудлагаар Дархан хотыг зорино. Гэвч тэнд Пантуг гэх түүний ооригчэн найз нь эцгийнх нь остонтой хуйвалдан урхи бэлдсэн байв. Аадарын эцэг хазгар Чука Мандалнарт эртний тооцоо байсныг Пантуг оорт ашигтайгаар эргүүлж найзыхаа золиослож орхино. Пантугын балгаар хайртай бүсгүй донгож мөндөлсөн бяцхан охиноосоо хагацсан Аадар ч бас ор сураггүй алга болно. Зургаан жилийн дараа гэнэт гарч ирсэн Аадар чухам юу хийж хэрхэх бол? Тэр амьдралаа эргүүлэн авч чадах болов уу?

Еврейн нолоотой гэр бүлээс гаралтай Бен-Хур-аас ромын ниргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Оргож эх орондоо ирээд өшөөгөө авна.

Хөмдөх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ. Уул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэрнийг хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно. Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлсэнгүй тас нуужээ..